

1. ТӨЛБӨР

1. Төлбөрийн нөхцөл

- 1.1. 12 хүнтэй групп: 900\$+онгоцны билет
- 10 хүнтэй групп: 940\$+онгоцны билет
- 8 хүнтэй групп: 1020\$+онгоцны билет
- 6 хүнтэй групп: 1100\$+онгоцны билет
- 4 хүнтэй групп: 1260\$+онгоцны билет
- 2 хүнтэй групп: 1660\$+онгоцны билет
- 1.2. Бэлэн болон бэлэн бусаар төлж болно.

2. Банкны мэдээлэл

- 2.1. Банкны нэр: Худалдаа хөгжлийн банк
- 2.2. Дансны нэр: Эм Би олон улсын унадаг дугуйн аяллын холбоо
- 2.3. Дансны дугаар: 470014041
- 2.4. Төлбөрийг хийхэд банкны баримт дээр төлөгчийн овог нэр, аль улс болон бусад холбогдох мэдээллийг тодорхой заасан байна.

3. Төлбөрийн нөхцөл

- 3.1. Бүртгэлээ хийхэд, урьдчилгаа төлбөр 500 долларыг төлж захиалгаа баталгаажуулна. Үлдэгдэл төлбөрийг аялал эхлэхээс сарын өмнө төлсөн байх ёстой.
- 3.2. Оператор компаниар дамжуулж захиалгаа хийсэн бол тухайн компаниараа дамжуулан харьцана.
- 3.3. Бүртгүүлсэний дараа аяллын зохион байгуулагч нь нэхэмжлэх явуулна. Нэхэмжлэлийн дагуу төлбөрөө хийнэ.
- 3.4. Аялалд оролцохоор бүртгүүлсэн дугуйчин ямар нэг шалтгаанаар оролцох боломжгүй болсон тохиолдолд тухайн аялагч зохион байгуулах багт аялал эхлэхээс нэг сарын өмнө албан ёсоор бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Энэ хугацаанд мэдэгдвэл төлбөрөөс 500 долларыг зохион байгуулагчийн зардалд тооцон суутгаж үлдэглэл төлбөрийг буцааж шилжүүлнэ.
- 3.5. Аялал зохион байгуулагч талаас цуцлагдвал төлбөрийг 100% буцааж шилжүүлнэ.
- 3.6. Аяллын дүрэм журам биелүүлээгүй болон аялалд оролцогчийн буруутай үйлдлээс болж аяллаас хасагдвал төлбөрийг буцаан олгохгүй.

4. Төлбөрийн дүнд дараах зүйлс багтана.

- 4.1. Аяллын бүртгэл
- 4.2. Галт тэрэгний зардал
- 4.3. Нисэх онгоцны буудал-Хустайн нуруу-Улаанбаатар хүртэл автобусны зардал
- 4.4. Унадаг дугуй болон бусад ачаа тээврийн хоёр талын зардал
- 4.5. Отгоос отог хүртэлх цүнх ачааны тээвэрлэлт
- 4.6. Аяллын хугацаан дахь бүх хоол
- 4.7. Аяллын туршид амрах, хоноглох байр
- 4.8. Аяллын аюулгүй байдал
- 4.9. Аяллын урд, хойно дагалдах автомашин
- 4.10. Газарчин
- 4.11. Нөхөн сэргээх халуун цай, кофе, ус, печень, боов

- 4.12. Нисэх онгоцны буудлаас угтан авах буюу хүргэж өгөх зардал
- 4.13. Зөөврийн жорлон
- 4.14. Улаанбаатар хотод байх зочид буудлын зардал

5. Төлбөрийн дүнд дараах зүйлс багтахгүй болно.

- 5.1. Аялагчын ирэх буцах нисэх онгоцны тасалбарын үнэ
- 5.2. Монгол Улсад нэвтрэн орох визний хураамж
- 5.3. Илүү ачааны төлбөр болон нисэх онгоцны буудлын татвар хураамж
- 5.4. Цайны мөнгө
- 5.5. Жуулчны бааз дахь шар айраг болон бусад ундааны нэр төрлүүд
- 5.6. Эрүүл мэндийн даатгал
- 5.7. “Төлбөрийн дүнд багтах зүйл” хэсэгт тодорхой зааж тодорхойлогдоогүй бүх зүйлс.

6. Нэмэлт

- 6.1. Хэрэв та тухайн улсад илүү удаан хугацаагаар байх хүсэлтэй байх болон төлбөрийн дүнд ороогүй үйлчилгээг авах тохиолдолд та манай “Хустай нуруу” аяллыг зохион байгуулж байгаа хамт олонд урьдчилан мэдэгдээрэй.